



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/605

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Байгалийн ургамлыг хамгаалах, хөрсний доройтлоос сэргийлэх зорилгоор Сансар 1, 2-р садны тохижилт (Булган сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Өвөлжөөн булаг” ХХК-тай 339,673,629 (гурван зуун гучин есөн сая зургаан зуун далан гурван мянга зургаан зуун хорин есөн) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д олгосугай

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Өвөлжөөн булаг” ХХК-ийн захирал (Б.Өлзийбаяр)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

5. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА


Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Засахирамж

6324010825

08 дугаар сарын 20-ны/ний өдрийн А.Б.С. дугаар захирамжийн хавсралт



Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Бумцэнд
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Бумцэнд
3	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Бумцэнд
4	Магадлашгүй ажил	5 559 535	Ү.Бямбасүрэн
5	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	2 779 768	Ү.Бямбасүрэн
6	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	19 500 000	Ү.Бямбасүрэн
7	Нормчлолын сан	500 358	Ү.Бямбасүрэн
8	Захиалагчийн техник хяналтын зардал	5 559 535	Ү.Бямбасүрэн
9	Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа	49 хоног	Ү.Бямбасүрэн